



СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



**ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧИН НИЙГМИЙН
ҮЗҮҮЛЭЛТ**

2020 ОН

АГУУЛГА

1. Хүн амын амьдарч буй орчин

1.1 Сууцны төрөл

1.2 Сууц эзэмшлийн хэлбэр

1.3 Цахилгаан эх үүсвэр

2. Онолын хэсэг

2.1 Гэмт хэргийн тухай ойлголт

2.2 Сэлэнгэ аймгийн гэмт хэргийн өнөөгийн байдал

3. Судалгааны хэсэг

3.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд

3.2 Корреляцийн болон ковариацийн коэффициент

3.3 Регрессийн тэгшитгэл

4. Дүгнэлт

Ном зүй

Хавсралт

Зургийн жагсаалт

Зураг.1 Өрхийн тоо, цахилгаан эх үүсвэрээр, 2019 он

Зураг.2 Ерөнхий статистик үзүүлэлт

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Өрхийн тоо, сууцны төрлөөр

Хүснэгт 2. Сууцны төрөл, эзлэх хувиар

Хүснэгт.3 Өрхийн тоо, сууц эзэмшлийн хэлбэрээр, 2019 он

Хүснэгт.4 Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, 2017-2019 он

Хүснэгт.5 Гэмт хэрэг, төрлөөр, 2018 он

Хүснэгт.6 Бүртгэгдсэн гэмт хэрэг /2002-2018 он/

Хүснэгт.7 Descriptiv stats

Хүснэгт.8 Корреляцийн болон ковариацийн коэффициент

Хүснэгт.9 Регрессийн шинжилгээ

I. ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН



1.1 Сууцны төрөл

“Хэрэгцээ гэж хүний амьд байх, амьдрахад зайлшгүй хангах шаардлагыг хэлнэ.” Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм. Төр, засгийн бодлогын нэг хэсэг нь хүн амаа орон сууцаар хангаж, тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэхэд чиглэдэг.

Хүснэгт 1. Өрхийн тоо, сууцны төрлөөр

Он	Бүгд	Үүнээс					
		Гэр	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр	Бусад сууц
2016	29 521	7 356	3 969	385	16 683	659	469
2017	29 912	7 495	4 021	387	16 870	665	474
2018	30 123	7 646	4 036	392	16 959	633	457
2019	29 015	7 231	4 048	383	16 318	598	437
<u>2019</u> <u>2018</u>	96.3	94.6	100.3	97.7	96.2	94.5	95.6

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

Сүүлийн 4 жилийн байдлаар Сэлэнгэ аймгийн нийт өрхийн тоо 2016 оноос 2018 он хүртэл 602(2.01%) өрхөөр нэмэгдсэн бол 2019 онд гадаадад амьдардаг хүмүүс болон 1 гишүүнтэй өрхүүдийг өрхийн мэдээллээс хассан нь өмнөх оноос 1108(3.7%)-иар буурсан байна. Үүнээс нийтийн байранд амьдардаг өрх хамгийн их буюу 35(5.5%) буурсан бол орон сууцанд 12 (0.3%) өрх нэмэгдэж бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2. Сууцны төрөл, эзлэх хувиар /2017-2019 он/

Он Сууцны төрөл	2016		2017		2018		2019	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	29 521	100.0	29 912	100.0	30 123	100.0	29 015	100.0
Гэр	7 356	24.92	7 495	25.1	7 646	25.4	7 231	24.9
Орон сууцны байшин	3 969	13.44	4 021	13.4	4 036	13.4	4 048	14.0
Бие даасан тохилог сууц	385	1.30	387	1.3	392	1.3	383	1.3
Сууцны тусдаа байшин	16 683	56.51	16 870	56.4	16 959	56.3	16 318	56.2
Нийтийн байр	659	2.23	665	2.2	633	2.1	598	2.1
Бусад сууц	469	1.59	474	1.6	457	1.5	437	1.5

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

2019 оны байдлаар нийт өрхүүдийн 56.2 хувь сууцны тусдаа байшинд, гэрт 24.9 хувийг, орон сууцны байшинд 14.0 хувь, нийтийн байранд 2.1 хувь, бусад

сууцанд 1.5 хувь, 1.3 хувь нь бие даасан тохилог сууцанд тус тус амьдарч байна. 2016 оноос 2019 он хүртэл орон сууцны байшинд амьдрах өрхүүд 0.3-1.3 функтээр жил өнгөрөх тусам нэмэгдсээр байна.

2019 оны байдлаар Сэлэнгэ аймгийн сумууд дахь нийт өрхийн гэрт амьдардаг хамгийн их хувийг Баруунбүрэн сум 65.6 хувь, Орхонтуул сум 58.9 хувь нь тухайн сууцны төрөлд амьдардаг бол Сүхбаатар сумд 3.8 хувь нь гэрт амьдарч байна. Орон сууцны байшинд хамгийн их хувийг Сайхан сум 47.4 хувь, Сүхбаатар сум 21.7 хувь нь эзэлж байгаа бол Баруунбүрэн сум, Зүүнбүрэн суманд тус сууцанд амьдардаг өрх байхгүй байна. Сууцны тусдаа байшинд Шаамар сумын нийт өрхийн 80 хувь нь амьдардаг бол Сайхан сумын 18.7 хувь нь тус сууцанд амьдарч байна (Хавсралт 1).

1.2 Сууц эзэмшлийн хэлбэр



Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ?, цаашид орон сууцны эрэлт, хэрэгцээ ямар байх вэ? зэрэг асуултад тодорхой хэмжээгээр хариулт өгөх үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт өрхийн 9.4 хувь буюу 2.7 мянган өрх өөрийн гэсэн орон сууцгүй байна. Шаамар, Сүхбаатар, Түшиг сумуудын нийт өрхийн 11-16 хувь бусдын орон сууцанд амьдардаг бол Баруунбүрэн, Орхонтуул сум хамгийн бага буюу 2.4-2.7 хувь нь бусдын орон сууц амьдардаг байна.

Хүснэгт.3 Өрхийн тоо, сууц эзэмшлийн хэлбэрээр, 2019 он

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

1.3 Цахилгааны эх үүсвэрээр Сэлэнгэ аймгийн дэд бүтцийн хөгжил нь



	Үүнээс				
	Бүгд	Бусад	Өөрийн сууцанд	Бусдын сууцанд түрээстэй	Бусдын сууцанд түрээсгүй
Алтанбулаг	1 251	1	1 115	44	91
Баруунбүрэн	838	-	818	2	18
Баянгол	1 621	2	1 461	41	117
Ерөө сум	1 864	1	1 724	42	97
Жавхлант	570	1	527	6	36
Зүүнбүрэн	796	1	745	13	37
Мандал	6 955	1	6 274	159	521
Орхон	677	2	622	7	46
Орхонтуул	1 045	-	1 017	5	23
Сайхан	2 708	2	2 530	110	66
Сант	650	-	581	15	54
Сүхбаатар	5 810	12	5 080	259	459
Түшиг	539	-	477	15	47
Хүдэр	672	-	652	7	13
Хушаат	558	-	532	8	18
Цагааннуур	1 336	-	1 201	9	126
Шаамар	1 125	-	944	58	123
Нийт	29 015	23	26 300	800	1 892

аймгийн төв болон сумын хувьд ихээхэн зөрүүтэй байна. Сүүлийн 3 жилийн байдлаар нийт өрхийн төвлөрсөн цахилгаан эх үүсвэртэй айл өрх 84.06 хувиас 83.7 хувь буюу 0.36 функтээр буурсан бол бусад цахилгаан эх үүсвэртэй өрх 0.27 функт, цахилгаан эх үүсвэргүй айл 0.08 функтээр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт.4 Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэр, 2017-2019 он

Он Эх үүсвэр	2016		2017		2018		2019	
	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Дүнд эзлэх хувь
Төвлөрсөн систем	24 871	84.2	25 143	84.1	25 287	83.9	24 286	83.7
Бусад эх үүсвэр	4 532	15.4	4 629	15.5	4 676	15.5	4 570	15.8
Цахилгааны эх үүсвэргүй	118	0.4	140	0.5	160	0.5	159	0.5
Нийт	29 521	100.0	29 912	100.0	30 123	100.0	29 015	100.0

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

Зураг.1 Өрхийн тоо, цахилгаан эх үүсвэрээр, 2019 он



2019 оны байдлаар нийт өрхийн 83.7 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсвэртэй, 15.75 хувь бусад эх үүсвэр буюу дизель станц, сэргээгдэх эрчим хүч, бага оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байна. Сүхбаатар, Шаамар, Мандал сумдын нийт өрхийн 94.8-99 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсвэрт холбогдсон бол Баруунбүрэн сумын нийт өрхийн 47.1 хувь нь төвлөрсөн цахилгаан эх үүсвэртэй боловч өрхүүдийн 49.5 хувь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан тог цахилгаан гарган авч байна.

II.ОНОЛЫН ХЭСЭГ

2.1 Гэмт хэргийн тухай ойлголт

Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Бусад гэмт хэрэг.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны суурин хүн амын тоонд харьцуулж тооцно.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагч гэнэ.

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, ял шийтгэл эдэлж байгаа болон ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй этгээдийг ял шийтгэгдсэн хүн гэнэ (Гэмт хэрэг, шүүхийн статистик-2015).

2.2 Сэлэнгэ аймгийн гэмт хэргийн өнөөгийн байдал

2018 оны байдлаар нийт 779 гэмт хэрэг бүртгэгдсэний 193 нь согтуугаар үйлдэгдсэн ба гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.9 хувиар өсч гэмт хэргийн илрүүлэлт 55.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.6 пунктээр буурсан байна. Өмнөх оны мөн үеэс Ерөө, Цагааннуур, Баруунбүрэн, Сүхбаатар сумдад гэмт хэрэг 7-54 гаралтаар өссөн байна.

Хүснэгт.5 Гэмт хэрэг, төрлөөр, 2018 он

Сумын нэр	Soum	Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг г/х, Crime against human life and health	Байгаль хамгаалах журмын эсрэг г/х Crimes against environmental protection rules	Өмчлөх эрхийн эсрэг г/х Crimes against the right of ownership	малын хулгай Livestock theft	Тээврийн хэрэгслийн хөд-ний аюулгүй байдлын эсрэг г/х Crimes against traffic safety and regulation of vehicle use	Бусад Other
ДҮН	Total	298	73	272	37	68	68
Алтанбулаг	Ab	7	6	16	1	3	13
Ерөө	Yer	32	22	5		3	6
Зүүнбүрэн	Zb	9		5	5	1	
Мандал	Ma	99	7	77	5	11	10
Орхон	Or	6	1	4	1	5	
Сант	Sa	2	5	2	1	2	
Цагааннуур	TSn	6	1	13	4	1	2
Баянгол	Bg	11	3	12	1	14	2
Сайхан	Sn	18		15	3	10	9
Орхонтуул	Ot	3		8	3		3
Баруунбүрэн	Bb	6	2	7	4	7	1
Шаамар	Shr	9	1	7	1	6	
Хүдэр	Khr	7	21	2			2
Сүхбаатар	Sb	73		86	2	3	14
Жавхлант	Ja	3		4	2	2	1
Түшиг	Tu	5	3	2	1		4
Хушаат	Khu	2	1	7	3		1
Бусад аймаг	Other						

Эх үүсвэр: Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн байдал, 2018 он

Бүртгэгдсэн гэмт хэргийн 34.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 38.2 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 9.4 хувийг нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 8.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 8.8 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 13.6 хувийг малын хулгай эзэлж байна.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд

Сэлэнгэ аймгийн тоон мэдээлэл дээр 2002 оноос 2018 он хүртэл бүртгэгдсэн гэмт хэрэг, ажилгүйдлийн түвшин, ДНБ-ний өсөлтийн түвшингээр дүн шинжилгээ хийв.

Хүснэгт.6 Бүртгэгдсэн гэмт хэрэг /2002-2018 он/

Он	crime	gdp rate	alcohol product rate
2002	1 171	2.8	132.2
2003	879	-11.2	6.6
2004	906	1.1	-45.8
2005	933	32.7	54.5
2006	816	73.6	77.4
2007	853	30.6	17.6
2008	960	57.3	-6.9
2009	814	-9.2	-48.3
2010	797	108.8	-25.2
2011	618	-8.4	-2.4
2012	704	22.8	22.7
2013	679	10.9	2.5
2014	755	19	106.5
2015	793	-2	5.7
2016	669	-3.3	9.5
2017	729	7.7	0.7
2018	779	15.3	15.8

Эх үүсвэр: 1212.mn


Ерөнхий статистик үзүүлэлтээс харвал бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2002 оноос 2018 он хүртэл дунджаар 815 байсан бол дунджаасаа хазайх хазайлт нь 132 байна.

Хүснэгт.7 Descriptiv stats

Sample: 2002 2018

	CRIME	ALCOHOL_PRO	GDP_RATE
Mean	815.0000	19.00588	20.50000
Median	797.0000	6.600000	10.90000
Maximum	1171.000	132.2000	108.8000
Minimum	618.0000	-48.30000	-11.20000
Std. Dev.	132.1812	48.73780	32.59285
Skewness	0.985396	0.922400	1.428735
Kurtosis	4.200495	3.282141	4.351497
Jarque-Bera	3.772025	2.467047	7.077438
Probability	0.151675	0.291264	0.029051
Sum	13855.00	323.1000	348.5000
Sum Sq. Dev.	279550.0	38005.97	16996.70
Observations	17	17	17

Зураг.2 Ерөнхий статистик үзүүлэлт



Нормал тархалттай гэж дэвшүүлсэн таамаглалын статистик утга нь 0.15, 0.29, 0.029 байгаа нь нормаль тархалттай гэсэн таамаглал няцаагдсангүй. Jarque-Bera статистикийн таамаглал хүлээн зөвшөөрөгдөх магадлалыг илэрхийлдэг бөгөөд 0.1-ээс их утгатай гарвал нормаль тархалттай гэсэн таамаглал няцаагдахгүй болохыг илэрхийлнэ.

3.2 Корреляцийн болон ковариацийн коэффициент

Корреляцийн коэффициент нь хоёр хувьсагчийн хоорондын хамаарлыг илэрхийлдэг байхад хоёр хувьсагчийн хамаарлын хүчийг хэмждэг. Өөрөөр хэлбэл, ковариацийн коэффициент нь хоёр хувьсагчийн хооронд зөвхөн хамааралтай байна гэдгийг харуулдаг бол корреляцийн коэффициент нь энэ хоёр хувьсагч бие биеэсээ хэр хүчтэй хамаарч байгааг харуулдаг.

Хүснэгт.8 Корреляцийн болон ковариацийн коэффициент

Covariance Analysis: Ordinary
Date: 04/03/20 Time: 17:20
Sample: 2002 2018
Included observations: 17

Covariance Correlation	CRIME	ALCOHOL_PRO	GDP_RATE
CRIME	16444.12		
ALCOHOL_PRO	2298.712	2235.645	
GDP_RATE	449.9294	102.3376	999.8059
	0.110964	0.068450	1.000000

Дээрх хүснэгтээс харахад бүртгэгдсэн гэмт хэрэгт архины үйлдвэрлэлийн жилийн өсөлттэй ковариацийн коэффициент 2298.712, корреляцийн коэффициент нь 0.38 байгаа нь эерэг сул хамааралтай байна. Харин дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өсөлттэй ковариацийн коэффициент 449.9294 буюу эерэг хамааралтай байна. Корреляцийн коэффициент нь 0.111 байгаа нь гэмт хэргийн тоо ДНБ өсөлт 2-ын хооронд сул, эерэг хамааралтай болохыг харуулж байна.

Covariance Analysis: Ordinary

Date: 04/03/20 Time: 17:45

Sample: 2002 2018

Included observations: 17

Covariance			
Correlation		ALCOHOL_PRO	GDP_RATE
ALCOHOL_PRO		2235.645 1.000000	
GDP_RATE		102.3376 0.068450	999.8059 1.000000

Архины үйлдвэрлэлийн жилийн өсөлт ДНБ-ний өсөлттэй ковариацийн коэффициент болон корреляцийн коэффициент нь эерэг сул хамааралтай байна.

3.3 Регрессийн тэгшитгэл

Хүснэгт.9 Регрессийн шинжилгээ

Dependent Variable: CRIME

Method: Least Squares

Date: 04/03/20 Time: 17:20

Sample: 2002 2018

Included observations: 17

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	788.6582	39.30017	20.06755	0.0000
ALCOHOL_PRO	1.012353	0.669445	1.512227	0.1527
GDP_RATE	0.346395	1.001057	0.346029	0.7345
R-squared	0.150994	Mean dependent var		815.0000
Adjusted R-squared	0.029707	S.D. dependent var		132.1812
S.E. of regression	130.2030	Akaike info criterion		12.73485
Sum squared resid	237339.7	Schwarz criterion		12.88189
Log likelihood	-105.2462	Hannan-Quinn criter.		12.74947
F-statistic	1.244935	Durbin-Watson stat		0.741949
Prob(F-statistic)	0.317962			

$\beta_2=1.01$ гэдэг нь бусад хүчин зүйлс өөрчлөлтгүй тогтмол байхад архины үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 10 хувиар өсөхөд гэмт хэрэг жилд дунджаар 10 тохиолдлоор өснө.

$\beta_3=0.3$ гэдэг нь бусад хүчин зүйлс өөрчлөлтгүй тогтмол байхад дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 10 хувиар өсөхөд гэмт хэрэг жилд дунджаар 0,03 тохиолдлоор өснө.

IV. ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд өрхийн тоо буурсан үзүүлэлттэй байна. 2019 оны байдлаар нийт өрхүүдийн 56.2 хувь сууцны тусдаа байшинд, 24.9 хувь нь гэрт, 18.9 хувь нь бусад орон сууцанд амьдарч байна. Сэлэнгэ аймгийн нийт өрхийн 34.0 хувь нь хотод, 66.0 хувь хөдөө амьдарч байна.

Сэлэнгэ аймгийн гэмт хэргийн тоо 2016 оноос 2018 он хүртэл 110(14.1%) тохиолдлоор нэмж бүртгэгдсэн нь аймгийн хэмжээнд санаа зовоосон асуудал болж байна. Гэмт хэрэг үйлдэх гол асуудлууд нь ядуурал, ажилгүйдэл, архидалтаас ихээхэн шалтгаалж байгаа билээ. Архины үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлт 10 хувиар өсөхөд гэмт хэргийн тоо жилд дунджаар 10 тохиолдлоор нэмэгдэж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 10 хувиар өсөхөд гэмт хэрэг жилд дунджаар 0.03 тохиолдолоор нэмэгдэж байгаа нь гэмт хэрэгт нөлөөлөх хамаарал багатай байна гэсэн дүгнэлт гарч байна. Иймээс Сэлэнгэ аймгийн гэмт хэргийн тоог бууруулахын тулд жилд үйлдвэрлэх архины хэмжээг бууруулах нь зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, НОМ ЗҮЙ

1. Аймгийн 2018 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулага
2. www.1212.mn сайт
3. Хүн ам, өрхийн мэдээллийн сан
4. Eviews 9 програмыг шинжилгээнд ашиглах нь
5. Хүн амын амьдарч буй орчин, нийгмийн зарим үзүүлэлт 2018 он

ХАВСРАЛТУУД

Өрхийн тоо, сууцны төрлөөр /2019 он/

Сум	Бүгд	Үүнээс					
		Гэр	Орон сууцны байшин	Бие даасан тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Нийтийн байр	Бусад сууц
Алтанбулаг	1 251	217	55	8	928	37	6
Баруунбүрэн	838	550			285	2	1
Баянгол	1 621	587	95	3	909	17	10
Ерөө	1 864	349	143	4	1 222	71	75
Жавхлант	570	290	3		272	2	3
Зүүнбүрэн	796	280		1	504	3	8
Мандал	6 955	1 239	993	37	4 332	104	250
Орхон	677	361	12		294	3	7
Орхонтуул	1 045	615	143	2	283	2	
Сайхан	2 708	875	1 284	18	492	22	17
Сант	650	344	10		289	5	2
Сүхбаатар	5 810	219	1 259	307	3 728	273	24
Түшиг	539	133	1		398	1	6
Хүдэр	672	142	1		512	1	16
Хушаат	558	319	1	1	230	4	3
Цагааннуур	1 336	583	6		740	4	3
Шаамар	1 125	128	42	2	900	47	6
Нийт	29 015	7 231	4 048	383	16 318	598	437

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан

Өрхийн тоо, цахилгааны эх үүсвэрээр /2019 он/

Сум	Бүгд	Үүнээс				
		Төвлөрсөн систем	Дизель станц	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Бага оврын цахилгаан үүсгүүр	Цахилгааны эх үүсвэргүй
Алтанбулаг	1 251	1 004	5	105	132	5
Баруунбүрэн	838	395	2	415	6	20
Баянгол	1 621	1 256		302	53	10
Ерөө	1 864	1 557	3	247	51	6
Жавхлант	570	283		264	21	2
Зүүнбүрэн	796	510		259	22	5
Мандал	6 955	6 595	1	217	119	23
Орхон	677	343		328	5	1
Орхонтуул	1 045	600	1	387	56	1
Сайхан	2 708	2 333	4	324	33	14
Сант	650	367	1	205	64	13
Сүхбаатар	5 810	5 752	1	10	44	3
Түшиг	539	418		115	4	2
Хүдэр	672	574	2	82	9	5
Хушаат	558	309		199	4	46
Цагааннуур	1 336	924	1	402	6	3
Шаамар	1 125	1 066	2	56	1	
Нийт	29 015	24 286	23	3 917	630	159

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан